



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/233

Номгон

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А\33 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг технологит хугацаанд гүйцэтгэн хагас, бүтэн жилээр тайлагнахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст (Т. Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310589